

Хэдийгээр газар нутгийн ихээхэн хэсгийг бэлчээрийн газар эзэлдэг ч торийн зүгээс энэ талаар баримтлах бодлого сул, газрын холбогдолтой хууль эрхзүйн бичиг баримтууд оноог хүртэл хоорондоо зорчилдоонтэй хэвээр байна. Газрын асуудлыг бодлогын твшинд авч үзэн, малчид, олон нийтийн санал зовломж дээр үндэслэн хууль эрхзүйн орчныг тодорхой, амьдралд хэрэгжихүйц, цэгц болгох шаардлагатай байгаа юм.

Тосол хэрэгжиж эхэлсэн цагаасаа бэлчээрийг зүй зохистой ашиглах, хамгаалах, бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох хууль эрхзүйн таатай орчин бүрдүүлэх чиглэлээр холбогдох яам, агентлагууд, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, бусад тосол хотолборвдтэй хамтран бага хурлууд, хуулийн тослийн хэлэлцүүлэг, маргаан зохион байгуулж, телевизийн ярилцлага, нэвтрүүлэгт оролцон, бодитой хувь нэмрээ оруулж байна.

“Бэлчээрийн тухай” хуулийн тослийг боловсруулахаар УИХ-ын Байгаль Орчин, Хvнс, Ходоо Аж Ахуйн Байнгын Хорооны тогтоолоор томилогдсон ажлын хэсэгт тослийн мэргэжилтнүүд оролцон ажилласан бөгөөд уг хуулийн тослийг хэлэлцүүлэх, олон нийтийн хүртээл болгох зэрэг бүхий л ажилд тослоос хамтран ажиллаж, санхүүгийн дэмжлэг үзүүлсээр ирлээ. Монголын Бэлчээрийн Менежментийн Холбоо, Ногоон Алт тослоос хэрэгжүүлсэн ажлынхаа туршлага, шинэ үзэл баримтлалд тулгуурласан “Бэлчээрийн тухай” хуулийн тослийн хувилбарыг боловсруулж бодлого боловсруулагчдад хүргүүлсэн нь УИХ-д оргон баригдаад байгаа хуулийн тослийг боловсронгуй болгох, зүйл заалтуудын амьдралд нийцтэй болгож, хэрэгжих ноцлолийг бүрдүүлэхэд үнэтэй эх сурвалж болж байна. Энэ чиглэлээр хэрэгжүүлсэн ажлуудыг дурдвал:

- 2007 онд УИХ-ын Байгаль Орчин, Хvнс, Ходоо Аж Ахуйн Байнгын Хороо, Хvнс, Ходоо Аж Ахуйн Яам, Газрын Харилцаа, Геодези, Зураг зүйн Газар, аймгуудын Засаг Даргын Тамгын Газар, “Ногоон Алт” тосол хамтран “Бэлчээрийн тухай хууль”-ийн тослийн хэлэлцүүлгийг 6 аймагт явуулж, орон нутаг, ард иргэд, малчдын саналыг авч, УИХ-д оргон барьсан.

- 2009 оны 10-р сард Хvнс ходоо аж ахуй, хонгон үйлдвэрийн яам, Байгаль орчны газар, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний газар, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн болон бусад байгууллагын удирдлага, мэргэжилтнүүдийг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулав.

- 2010 оны 10 дугаар сарын 21-нд **“Бэлчээрийн эрхзүйн орчинг боловсронгуй болгох асуудал”** сэдэвт бага хурлыг УИХ-ын Байгаль орчин, Хvнс, Ходоо Аж Ахуйн байнгын хороо, Хvнс, Ходоо Аж Ахуй, Хонгон Үйлдвэрийн Яам, “Тогтвортой Амьжиргаа 2”, “Ногоон Алт”, “Хот орчмын бэлчээрийн”

тосолтэй хамтран Улаанбаатар хотноо торийн ордонд зохион байгуулав. Бага хуралд 21 аймгийн малчид, торийн ба ТББ-ын толоолол 500 орчим толоологчид оролцлоо.

- 2011 оны 3-р сарын 17-ны одор ХХААХҮЯ-тай хамтран “Бэлчээрийн тухай хуулийн тосол”-ийн хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Энэхүү хэлэлцүүлгийн үндсэн зорилго нь мэргэжилтнүүдээс санал авах замаар УИХ-д оргон барьсан хуулийн тослийг боловсронгуй болгох үндсэн чиглэлүүдийг хамтран тогтох явдал байв. Хэлэлцүүлэгт хуулийн тослийг санаачлагчдын толоолол, тослийг боловсруулсан ажлын хэсэг, торийн ба иргэний нийгмийн байгууллага, эрдэм шинжилгээ, мэргэжлийн байгууллагуудын толоолол болох эрдэмтэн судлаачид, тухайн чиглэлээр хэрэгжиж буй тосол, хотолборнуудийн толоолол оролцлоо.

Үүнээс гадна Монгол оронтой ижил тостэй бэлчээрийн харилцаатай орнуудын хууль, эрхзүйн зохицуулалтыг харьцуулан судлах ажлыг эхлүүлээ. ОМОН-ын “Нутаг бэлчээрийн хууль” (1982 он), УИХ-ын ХХААБОБХ-ны хэсэлтээр БНХАУ-ын “Тал хээрийн бүсийн тухай” (2002 он) хуулийг орчуулж, хууль боловсруулагчид, олон нийтийн хүртээл болголоо.